

11-р анги 11.11в "Дунджууд ба хазайлтууд" сэдвийн бие даалтын бодлогууд

1. $A = \{1, 1, 2, 4, 7\}$ өгөдлийн стандарт хазайлтыг олно уу?
2. Хэсэг сурагчаас шалгалт авсны дараа зөв гүйцэтгэсэн бодлогын тооны тархалтыг дараах хүснэгтээр үзүүлжээ.

Бодлогын тоо	$0 \leq x < 3$	$3 \leq x < 6$	$6 \leq x < 9$
Сурагчдын тоо	8	23	9

Нэг хүүхэд дунджаар хэдэн бодлого бодсон бэ?

3. Х санамсаргүй хувьсагчийн магадлалын тархалт дараах хүснэгтээр өгөгджээ. Математик дундаж нь хэд вэ?

X	2	5	3	1	
P	0.4	0.2	0.3	0.1	

4. Анги 10 хүү, 20 охинтой бөгөөд дундаж оноо 80 байв. Харин охидын дундаж оноог X гэвэл хөвгүүдийн авсан дундаж оноог X -ээр илэрхийл.
5. А ба В сурагчийн 20 эмэгтэй сурагчийн өндрийн хэмжсэн өгөгдөл доор өгөгджээ.

A	169	168	173	155	163	160	174	170	177	166	164	173	161	163	169	177	174	169	166	163
B	150	162	174	163	166	154	176	158	162	160	152	160	152	160	152	164	170	160	161	179

- а. Дундаж ба медианыг ол.

- б. Доод, дээд квантил ол.

6. 10, 19, 15, 15, 8, 8, 19, 19, 20 өгөгдлийн моод, медиан арифметик дундаж, далайц ол.
7. 15 сурагчийн математикийн шалгалтын дүн иш навчны диаграммаар өгчээ. Энэ шалгалтын медиан болон арифметик дундаж ол

Иш	навч
/аравтын/	/нэгжийн/

		Давталтын
1	7	1
3	2	1
p	0 1 5 5 7 9	6
q	3 5 8	3
6	6	1
8	4 5 6	3

8. Өгсөн давтамжийн хүснэгтээс хуримтлагдсан давтамжийн хүснэгтийг байгуулж медиан далайц ол.

X	3	4	5	6	7
---	---	---	---	---	---

Давтамж	8	10	17	9	8
---------	---	----	----	---	---

9. 3-р бодлогын давтамжийн хүснэгтээс квартил хоорондын далайц ол.
10. 16 настай эмэгтэй сурагчдын өндрийн талаар дараах мэдээлэл өгөгджээ.
Хамгийн намхан - 146 см
Доод квартил - 158 см
Медиан – 166 см
Дээд квартил – 170 см
Хамгийн өндөр – 180 см

Квартил хоорондын далайц ол.